



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2022 оны 07 сарын 04 өдөр

Дугаар А/348

Улаанбаатар хот

Магадлан итгэмжлэл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх зөвлөлийн 2022 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн 11 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын нэрсийг хавсралтаар баталж, батламжийг олгосугай.
2. Магадлан итгэмжлэлийн хугацаа тасарч сунгагдаж буй эрүүл мэндийн байгууллагуудын магадлан итгэмжлэл эхлэх хугацааг 2022 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн тооцсугай.
3. Магадлан итгэмжлэлийн хугацаанд тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах ажлыг тасралтгүй зохион байгуулж, шинжээчдийн багийн өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.
4. Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх зөвлөлийн 2022 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн 11 дүгээр хурлын шийдвэрийг холбогдох эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төрийн захиргаа удирдлагын газар /П.Эрхэмбаяр/-т, Эрүүл мэндийн хөгжлийн төв /Б.Нарантуяа/ -д тус тус үүрэг болгосугай.
5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /С.Төгсдэлгэр/-т даалгасугай.

САЙД



С.ЭНХБОЛД

141221698

Эрүүл мэндийн сайдын 2022 оны 07
дугаар сарын 04 - ны өдрийн 14/318
дугаар тушаалын хавсралт

МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДСЭН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН НЭРС

№	Эрүүл мэндийн байгууллагын нэрс	Батламжийн Дугаар	Магадлан итгэмжлэгдсэн хугацаа	Магадлан итгэмжлэл эхлэх огноо	Магадлан итгэмжлэл дуусах огноо
1.	"Амин-Эрдэнэ" ХХК-ний эмнэлэг	219/2022	3 жил	2022.07.05	2025.07.05
2.	"Орбита ХХК"-ний эмнэлэг	220/2022	4 жил	2022.07.01	2026.07.01
3.	Баянзүрх дүүрэг, Хонхор тосгоны эрүүл мэндийн төв	221/2022	2 жил	2022.07.25	2024.07.25
4.	Баянзүрх дүүрэг, Эмнэхүй өрхийн эрүүл мэндийн төв	222/2022	3 жил	2022.07.08	2025.07.08
5.	Сүхбаатар дүүрэг, Энхсүндэр өрхийн эрүүл мэндийн төв	223/2022	3 жил	2022.07.08	2025.07.08
6.	Баянхонгор аймаг, "Оточ Номгон" өрхийн эрүүл мэндийн төв	224/2022	3 жил	2022.08.01	2025.08.01
7.	Баянхонгор аймаг, "Оточ мандал" өрхийн эрүүл мэндийн төв	225/2022	3 жил	2022.09.01	2025.09.01
8.	Баянхонгор аймаг, "Жинст" сумын эрүүл мэндийн төв	226/2022	3 жил	2022.07.25	2025.07.25
9.	Баянхонгор аймаг, "Баян-Энэрэл" ХХК-ний эмнэлэг	227/2022	3 жил	2022.07.25	2025.07.25
10.	Ховд аймаг, Булган сум, Булган өрх ЗБН	228/2022	2 жил	2022.07.01	2024.07.01
11.	Ховд аймаг, Хилийн цэргийн 0130 дугаар ангийн Эрүүл мэндийн төв	229/2022	1 жил	2022.07.01	2023.07.01

оо0оо